



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 176

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Анд Энерги” ХХК нь нээлттэй хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулагдсантай холбогдуулан тус компанийн нэг бүр нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 78,070,758 /далан найман сая далан мянга долоон зуун тавин найман/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, арилжаа эрхлэх байгууллагын жагсаалтад бүртгэхийг “Монголын Үнэт цаасны бирж” ХХК /С.Даваасамбуу/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Анд Энерги” ХК-ийн нэг бүр нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 51,526,700 /тавин нэгэн сая таван зуун хорин зургаан мянга долоон зуун/ ширхэг хувьцааг өмчлөх эрхийг энэхүү тогтоолын хавсралт 1-т заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 26,544,058 /хорин зургаан сая таван зуун дөчин дөрвөн мянга тавин найман/ ширхэг хувьцааг тус бүрийн үнийг 60 /жаран/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг зөвшөөрсүгэй.

4. Нийтэд санал болгон худалдаалах хувьцааны 80 ба түүнээс дээш хувийг анхдагч зах зээлд арилжаалсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцох бөгөөд зарагдаагүй үлдсэн хэсгийг худалдаж авахыг “Бумбат-Алтай ҮЦК” ХХК /Ш.Батжаргал/-д үүрэг болгосугай.

5. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг тусгаарлахыг “Монголын Үнэт цаасны бирж” ХХК /С.Даваасамбуу/-д үүрэг болгосугай.

6. “Анд Энерги” ХХК нь компанийн хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Анд Энерги” ХХК /Ц.Гүррагчаа/-д үүрэг болгосугай.

7. Энэхүү тогтоолын 3-т заасан нийтэд санал болгон худалдаалах хувьцааны 80 ба түүнээс дээш хувийг анхдагч зах зээлд арилжаалж, шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй, зарагдаагүй үлдсэн хэсгийг худалдаж аваагүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг "Бумбат-Алтай ҮЦК" ХХК /Ш.Батжаргал/-д анхааруулсугай.

8. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 176 дугаар тогтоолын хавсралт



Д/д	Хувьцаа эзэмшигчдийн нэр	"Анд Энерги" ХХК-д эзэмших хувьцаа	"Анд Энерги" ХХК-ийн эзэмших хувь
1.	Төмөрбатын Барс	12,881,675	16.5%
2.	Цэнд-Аюушийн Гуррагчаа	12,881,675	16.5%
3.	Далхаагийн Мөнхбаяр	12,881,675	16.5%
4.	Ганхуягийн Түвшин	12,881,675	16.5%
	Нийт дүн	51,526,700	66%